



Global Affairs
Canada

Affaires mondiales
Canada

Макро түвшний хүчин зүйлсийг ойлгохын тулд том зургаар харах нь

Эх сурвалж: Гарын авлагын Бүлэг 2-ын 14-23-р нүүр, Бүлэг 9-ийн 78-80-р нүүр

Агуулга

Жендэрийн практик хэрэгцээ, стратегийн сонирхол

Макро түвшний хариуцлага

Улсын салбарын эдийн засаг

Орлого бүрдүүлэлт, татвар ногдуулалтын үр нөлөө,
нөлөөлөл

Макро түвшин дэх зөрүүтэй байдал, нийгэмд чиглэсэн
төсвийн зарлагын сонголт

Нарийвчилсан шинжилгээ, шийдвэр гаргалт

Нийгэмшүүлэх болон соёлын бодлого

Практик хэрэгцээ

- Жендэрийн практик буюу бодит хэрэгцээ нь эмэгтэй, эрэгтэй хүмүүст нийгмээс оноосон уламжлалт жендэрийн үүрэгтэй холбоотой ажил үүрэг, хариуцлага, бодит нөхцөл байдлаас урган гарсан хэрэгцээ юм.
- Практик хэрэгцээг анхаарч хангах нь амьдралын чанарыг сайжруулдаг боловч жендэрийн ялгарал болон эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэмд эзлэх байр суурийг өөрчилдөггүй.
- Ерөнхийдөө практик хэрэгцээнд олдож буй боломж нөхцөл, хүртээмжийн асуудал яригддаг.

Стратегийн сонирхол

- Жендэрийн стратегийн сонирхол нь нийгмийн хүрээнд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн байр суурийг бие биетэй нь харьцуулж харахад голлон анхаардаг.
- Стратегийн сонирхолд шийдвэр гаргах эрх мэдэл, нөөц баялгийг хянах эрх орно.
- Жендэрийн стратегийн сонирхлыг анхаарч үзэх нь эмэгтэй, эрэгтэй хүмүүс бүхий л хүрээнд тэгш байдалтай болж, өнөөгийн нийгмийн жендэрийн үүрэг, хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд тустай.
- Жендэрийн стратегийн сонирхолд ерөнхийдөө албан тушаал, хяналт, эрх мэдлийн асуудал ордог.

Макро түвшний хариуцлага

- Охид эмэгтэйчүүд нийгэм, улс төр, соёл, эдийн засгийн хүрээнд эрхээ бүрэн эдлэхэд олон саад бэрхшээлтэй тулгардаг. Төр эдгээр саад бэрхшээлийг арилгаж, эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хооронд тэгш байдлыг бодитойгоор тогтоох үүрэгтэй.
- Макро-эдийн засгийн бодлого нь жендэрийг авч үзэхгүйгээр эдийн засгийн ерөнхий үзүүлэлтүүдийг анхаарч зохицуулдаг. Энэ нь жендэрийн харалган байдал юм.

Макро эдийн засаг

- Макро эдийн засгийн бодлогын зорилтуудыг ихэвчлэн явцуу тодорхойлсон байдаг бөгөөд нийт эдийн засгийн өсөлтийг хурдасгаж, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн байдаг. Гэвч бодлогын өргөн хүрээний зорилт, нийгэмд үзүүлэх үр өгөөжөөс илүүтэйгээр эдийн засгийн өсөлт, мөнгө санхүүгийн зорилтот түвшинд хэт анхаардаг нь эдийн засгийн бүхий л бодлого эцсийн зорилгоосоо (бүх хүн эдийн засаг, нийгмийн хүрээнд эрхээ бүрэн эдлэх боломж олгох) хазайхад хүргэдэг.

Тогтолцооны алдаа

- Өнөөдрийн макро-эдийн засгийн тогтолцоо нь эмэгтэйчүүд цалингүй асран халамжлах ажлыг (хоол хийх, гэр орноо цэвэрлэх, гэр бүлийнхээ хүүхэд, хөгшид, өвчтэй хүмүүсийг асрах) дангаараа үүрэх зэрэг тогтолцооны шинжтэй сул талыг бүрэн шийдвэрлэж чадахгүй байна.
- Хэдийгээр цалингүй асран халамжлах ажлыг хэмжиж, үнэлж, тусгадаггүй боловч энэ нь аливаа эдийн засгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлд төдийгүй охид эмэгтэйчүүд эрхээ зохих ёсоор эдлэхэд шууд нөлөөлж байна.

Улсын салбарын эдийн засаг

- Төрийн бодлогыг эдийн засгийн үр ашиг, тэгш эрхийн талаас нь судлан шинжлэхийг хэлнэ. Улсын салбарын эдийн засаг нь халамжийн эдийн засгийн онолд тулгуурладаг бөгөөд үүнийг эцсийн дүнд нь нийгмийн халамжийг сайжруулах арга хэрэгсэл байдлаар ашигладаг.

Төсвийн зарлага, санхүүгийн эгэх хариуцлагын хөтөлбөрийн 9 шалгуур үзүүлэлт (1)

- Төсөв, төсөв санхүүгийн бодлогын саналд хийх жендэрийн нөлөөллийн дүн шинжилгээ;
- Төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн жендэрийн мэдрэмжтэй менежмент;
- Жендэрийн мэдрэмжтэй төсвийн удирдамж;
- Жендэрийн мэдрэмжтэй төсвийн санал, баримт бичиг боловсруулалт;
- Төрийн үйлчилгээний гүйцэтгэлийн хүйсээр ангилсан мэдээлэл;
- ...

Төсвийн зарлага, санхүүгийн эгэх хариуцлагын хөтөлбөрийн 9 шалгуур үзүүлэлт (2)

- ...
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангахын төлөөх зарцуулсан төсвийг тусгайлан бүртгэж, тайлагнах;
- Жендэрийн мэдрэмжтэй тайлагнал;
- Төрийн үйлчилгээний жендэрийн нөлөөллийн үнэлгээ;
- Төсвийн жендэрийн нөлөөллийн эрхзүйн (нийцлийн) хяналт шалгалт.

Төсвийн орлого бүрдүүлэлт, татвар ногдуулалт

- Засгийн газрын орлого бүрдүүлэх арга зам нь эмэгтэй, эрэгтэй хүмүүст ялгаатай нөлөөлдөг. Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг татварын ерөнхий бодлогод тусгах нь төрийн бодлогын чанарыг мэдэгдэхүйц сайжруулдаг.

Жишээ: Татвар

- Тухайлбал, өсөн нэмэгдэх хувь хэмжээ бүхий хувь хүний орлогын албан татварын тогтолцоо нь гэрлэсэн хосууд хамтдаа орлогоо тайлагнаж, татвар төлөх боломжийг олгодог улс орнуудад бага орлого олж буй хүнд ч гэсэн тогтоосон дүнгээс илүү гарсан орлогод өндөр хувь хэмжээтэй татвар ногдуулдаг. Энэ нь эмэгтэйчүүдийн орлого ихэвчлэн нөхрийнхөөсөө бага байдаг тул эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдээс илүү нөлөөлөх нь элбэг.

Макро түвшний зөрүү

- Жендэрийн цалингийн зөрүү
- Боловсролын түвшний зөрүү
- Тэтгэврийн зөрүү
- Улс төр дэх төлөөлөл, оролцооны зөрүү
- Шийдвэр гаргах албан тушаал дахь зөрүү
- Өмч, хөрөнгө эзэмших байдал дахь зөрүү.

Төсвийн зарлагын сонголт

- Хүүхэд халамжлах тогтолцоог дэмжихийн ач холбогдол
- Асран халамжлагчдад дэмжлэг үзүүлэхийн ач холбогдол
- Шимтгэл төлөөгүй ч хувь тэнцүүлэн тэтгэвэр олгох нь ахмад насны эмэгтэйн амьжиргаанд эерэгээр нөлөөлнө.
- Нийтийн тээвэр эмэгтэйчүүдийн амьдралын чанарт чухал ач холбогдолтой.
- Олон нийтэд тэгш мэдлэг түгээх тогтолцоо, номын сангийн ач холбогдол

Нарийвчилсан шинжилгээ

- Одоог хүртэл бид төрийн байгууллагын зарцуулж буй зардлын нэн даруй гарах үр дагаврыг хэмжих талаар ярьсан. Бид байгууллага оршин байгаа үндэслэл, өөрийн үйл ажиллагааны эрэгтэй, эмэгтэй хүмүүс болон бусад бодит харилцан хамаарал бүхий хүн ам, нийгмийн үзүүлэлтэд нөлөөлж буй гол хүчин зүйлсийг анхаарч судалбал зохино.

Нийгэмшилд төрийн үзүүлэх нөлөө

- Төр олон нийтэд боловсрол олгох, соён гэгээрүүлэхэд чиглэсэн арга хэмжээгээрээ дамжуулан хүүхдүүдийг хэрхэн нийгэмшүүлэх талаар ямар мэдээллийг хүн ам, айл өрх, эцэг эхчүүдэд өгч байна вэ?
- Уг мэдээлэл нь тэгш бус байдлыг өөгшүүлж, нэмэгдүүлж байгаа эсэх?

Соёлын бодлого

- Уламжлал, соёл, түүх, үлгэр домогт эмэгтэйчүүд хэрхэн, хэр зэрэг гардаг вэ? Бид тэдний хувь нэмрийг эн тэнцүү авч үздэг үү? Тэдний оруулж буй хувь нэмрийг зөвөөр үнэлж хүлээн авдаг уу?
- Бид ямар төрлийн соёл бий болгодог вэ?



Global Affairs
Canada

Affaires mondiales
Canada

Баярлалаа.

